

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрүүл мэндийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	13
4.3 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.МЯГМАРСҮРЭН ТАНАА

2022.02.26 № 2/75
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БӨЛДБААТАР



021020239

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	213,972,839.28	579,616,912.91
33	АВЛАГА	8,477,602.00	7,433,602.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,766,602.00	5,622,602.00
335	Бусад авлага	2,711,000.00	1,811,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,711,000.00	1,811,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	205,495,237.28	572,183,310.91
351	Түүхий эд материал	172,089,382.28	540,919,951.93
35130	Эм боох материал	172,089,382.28	540,919,951.93
354	Хангамжийн материал	33,405,855.00	31,263,358.98
35410	Бичиг хэргийн материал	4,993,725.00	6,554,575.00
35440	Түлш, шатах тослох материал	850,000.00	625,000.00
35450	Барилгын засварын материал	141,500.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	27,420,630.00	24,083,783.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	702,752,092.75	669,875,482.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	702,752,092.75	669,875,482.96
392	Биет хөрөнгө	656,472,292.75	623,595,682.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	500,013,000.00	500,013,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-17,335,272.32	-27,309,283.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	197,956,615.00	197,956,615.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-97,463,964.00	-121,044,847.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	290,420,490.00	321,336,897.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-242,513,644.25	-267,520,196.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,734,919.00	66,734,919.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,339,850.68	-46,571,420.96
393	Биет бус хөрөнгө	46,279,800.00	46,279,800.00
39303	Бусад биет бус хөрөнгө	46,554,800.00	46,554,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-275,000.00	-275,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	916,724,932.03	1,249,492,395.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	916,724,932.03	1,249,492,395.87
51	Засгийн газрын хувь оролцоо	916,724,932.03	1,249,492,395.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,173,950,895.00	1,173,950,895.00
51101	Өмч: - төрийн	1,173,950,895.00	1,173,950,895.00
512	Хуримтлагдсан үр дүн	-649,177,482.45	-316,410,018.61
51210	Өмнөх үеийн үр дүн	-649,177,482.45	-649,177,482.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	332,767,463.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	391,951,519.48	391,951,519.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	916,724,932.03	1,249,492,395.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,585,811,643.70	10,666,952,027.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	611,623,143.70	6,345,610,671.06
120	Нийтлэг татварын бус орлого	611,623,143.70	6,345,610,671.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	611,623,143.70	6,345,610,671.06

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	611,623,143.70	6,345,610,671.06
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,974,188,500.00	4,321,341,356.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,871,003,100.00	1,939,173,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,871,003,100.00	1,939,173,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,185,400.00	2,382,167,656.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,957,650.00	399,279,856.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,168,500.00	644,744,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,200,000.00	1,337,057,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,859,250.00	1,085,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,507,918,869.76	10,334,184,563.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,507,918,869.76	10,334,184,563.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,590,609,472.20	7,746,535,718.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,417,947.74	475,101,378.20
210101	Үндсэн цалин	249,162,232.69	270,554,133.00
210102	Нэмэгдэл	70,809,446.44	134,051,677.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,651,073.61	32,733,149.00
210104	Урамшуулал	36,795,195.00	37,762,419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,378,979.46	57,832,820.85
210201	Тэтгэврийн даатгал	34,828,079.46	40,725,720.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,887,700.00	4,276,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110,200.00	3,421,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,038,249.50	855,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,514,750.50	8,553,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,655,467.00	49,923,457.40
210301	Гэрэл, цахилгаан	4,442,142.00	4,738,857.40
210302	Түлш, халаалт	41,424,485.00	41,227,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,788,840.00	3,957,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,619,642.00	48,127,651.34
210401	Бичиг хэрэг	8,377,416.00	6,315,823.34
210402	Тээвэр, шатахуун	12,620,500.00	35,796,093.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,963,980.00	2,698,582.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,029.00	757,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,059,717.00	2,559,953.00
2105	Нормативт зардал	767,487,412.89	6,413,614,618.25
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	764,949,912.89	6,413,074,618.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,537,500.00	540,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,195,900.00	163,652,006.32
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,905,000.00	153,666,766.32
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,459,940.00
210604	Урсгал засвар	24,290,900.00	7,525,300.00
2107	Томилолт, зочны зардал	18,069,000.00	41,289,360.00
210702	Дотоод албан томилолт	18,069,000.00	41,289,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,281,000.00	19,463,442.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,375,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	868,000.00	846,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,300.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,600.00	158,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,663,600.00	14,909,832.00
210807	Газрын төлбөр	60,000.00	66,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	198,000.00	3,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	228,504,123.11	477,530,984.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,172,861.00	413,092,266.97
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,815,100.00	645,700.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,516,162.11	63,793,017.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	917,309,397.56	2,587,648,844.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	892,615,406.00	2,561,192,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	433,874,278.00	336,340,158.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	453,511,128.00	952,352,322.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,230,000.00	1,272,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,693,991.56	26,456,364.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,691,991.56	21,456,364.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>77,892,773.94</u>	<u>332,767,463.84</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,848,930.00	00.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	1,848,930.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-1,848,930.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>76,043,843.94</u>	<u>332,767,463.84</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,127,671,095.00	558,734,375.17	-907,620,917.29	778,784,552.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,054,949.00	1,054,949.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,127,671,095.00	558,734,375.17	-906,565,968.29	779,839,501.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-1,054,949.00	00.00	-1,054,949.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	114,133,038.22	114,133,038.22
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,173,950,895.00	391,951,519.48	-649,177,482.45	916,724,932.03
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,173,950,895.00	391,951,519.48	-649,177,482.45	916,724,932.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,173,950,895.00	391,951,519.48	-649,177,482.45	916,724,932.03
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	332,767,463.84	332,767,463.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,173,950,895.00	391,951,519.48	-316,410,018.61	1,249,492,395.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,974,648,500.00</u>	<u>4,321,341,356.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	460,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	460,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	460,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,974,188,500.00	4,321,341,356.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,871,003,100.00	1,939,173,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,871,003,100.00	1,939,173,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,185,400.00	2,382,167,656.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,957,650.00	399,279,856.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,168,500.00	644,744,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,200,000.00	1,337,057,900.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,859,250.00	1,085,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,965,001,300.00	4,321,341,356.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,965,001,300.00	4,321,341,356.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,047,661,902.44	1,733,692,511.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,065,871.44	474,057,378.20
210101	Үндсэн цалин	246,352,159.00	269,654,133.00
210102	Нэмэгдэл	70,267,443.83	133,907,677.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,651,073.61	32,733,149.00
210104	Урамшуулал	36,795,195.00	37,762,419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,640,554.00	57,832,820.85
210201	Тэтгэврийн даатгал	35,089,654.00	40,725,720.85
210202	Тэтгэмжийн даатгал	3,887,700.00	4,276,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,110,200.00	3,421,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	777,500.00	855,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,775,500.00	8,553,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,655,467.00	49,923,457.40
210301	Гэрэл, цахилгаан	4,442,142.00	4,738,857.40
210302	Түлш, халаалт	41,256,225.00	41,227,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,957,100.00	3,957,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,961,500.00	44,443,899.00
210401	Бичиг хэрэг	3,702,600.00	3,654,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,295,500.00	35,402,953.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,604,800.00	2,698,582.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,071,500.00	757,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,100.00	1,930,664.00
2105	Нормативт зардал	311,855,550.00	570,061,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	311,555,550.00	568,811,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,563,210.00	44,192,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,180,900.00	34,099,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,751,000.00	2,235,000.00
210604	Урсгал засвар	14,631,310.00	7,857,300.00
2107	Томилолт, зочны зардал	18,213,000.00	41,289,360.00
210702	Дотоод албан томилолт	18,213,000.00	41,289,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,014,600.00	22,547,242.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	3,375,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	868,000.00	846,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	203,300.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	237,600.00	158,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,397,200.00	17,993,632.00
210807	Газрын төлбөр	60,000.00	66,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	198,000.00	3,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,692,150.00	429,344,954.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,389,250.00	428,699,254.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,302,900.00	645,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	917,339,397.56	2,587,648,844.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	892,645,406.00	2,561,192,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	433,874,278.00	336,340,158.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	453,511,128.00	952,352,322.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,260,000.00	1,272,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,693,991.56	26,456,364.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,691,991.56	21,456,364.55
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,647,200.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,647,200.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,647,200.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,647,200.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,647,200.00	00.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,647,200.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,939,173,700.00	1,917,717,335.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,939,173,700.00	1,917,717,335.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,814,000.00	619,024,855.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,504,400.00	434,113,378.20
210101	Үндсэн цалин	269,654,100.00	269,654,133.00
210102	Нэмэгдэл	93,963,700.00	93,963,677.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,733,200.00	32,733,149.00
210104	Урамшуулал	38,153,400.00	37,762,419.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,832,900.00	57,832,820.85
210201	Тэтгэврийн даатгал	40,725,800.00	40,725,720.85
210202	Тэтгэмжийн даатгал	4,276,800.00	4,276,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,421,400.00	3,421,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	855,400.00	855,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,553,500.00	8,553,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,955,300.00	49,923,457.40
210301	Гэрэл, цахилгаан	4,770,700.00	4,738,857.40
210302	Түлш, халаалт	41,227,600.00	41,227,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,957,000.00	3,957,000.00
210304	Байрны түрээс	00.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,242,900.00	21,142,746.00
210401	Бичиг хэрэг	3,702,600.00	3,654,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,727,300.00	13,727,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,104,200.00	1,073,082.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757,500.00	757,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,951,300.00	1,930,664.00
2105	Нормативт зардал	4,598,500.00	3,811,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,561,300.00	2,561,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,037,200.00	1,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,321,000.00	16,192,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,765,300.00	6,099,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,500.00	2,235,000.00
210604	Урсгал засвар	17,847,200.00	7,857,300.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	84,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	4,497,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,068,500.00	16,067,242.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,375,000.00	3,375,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	846,300.00	846,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,900.00	54,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,300.00	158,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,514,100.00	11,513,632.00
210807	Газрын төлбөр	66,400.00	66,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,000.00	3,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20206500.00	19857811.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,560,800.00	19,212,111.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	645,700.00	645,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1304359700.00	1298692480.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,304,359,700.00	1,298,692,480.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	340,459,700.00	336,340,158.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	952,500,000.00	952,352,322.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,400,000.00	10,000,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,939,173,700.00	1,917,717,335.45
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,939,173,700.00	1,917,717,335.45
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,939,173,700.00	1,917,717,335.45
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	26	26
620003	Үйлчлэх ажилтан	3	3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Төгрөгөөр Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,183,400.00	2,382,167,656.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,183,400.00	2,382,167,656.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,183,400.00	1,114,667,656.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		39,944,000.00
210102	Нэмэгдэл		39,944,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,897,500.00	23,301,153.00
210402	Тээвэр, шатахуун	2,897,500.00	21,675,653.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,625,500.00
2105	Нормативт зардал	29,289,750.00	566,250,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,289,750.00	566,250,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,500,000.00	28,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		28,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,500,000.00	
2107	Томилолт, зочны зардал	13,716,000.00	41,205,360.00
210702	Дотоод албан томилолт	13,716,000.00	41,205,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,800,000.00	6,480,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,800,000.00	6,480,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,980,150.00	409,487,143.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,760,150.00	409,487,143.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,220,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000,000.00	1,267,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	1,262,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	282,800,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		5,000,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,183,400.00	2382167656.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,183,400.00	2,382,167,656.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	41,957,650.00	399,279,856.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,166,500.00	644,744,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,200,000.00	1,337,057,900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,859,250.00	1,085,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрүүл мэндийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд эмийн зарцуулалттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Мөнхтулга 2022 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн газар нь “Аймгийн Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрэлт хэрэгцээнд нь тулгуурлан өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэн эрүүл оюунлаг иргэний бий болгоно” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Эрүүл мэндийн үйл ажиллагааг зохицуулах.*
- *Засгийн газрын шийдвэр болон харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор Эрүүл мэндийн яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогын 867.4 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 86.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 60.7 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрүүл мэндийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 332.8 сая төгрөгөөр буюу 36.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, цэвэр хөрөнгө өмчийн дүнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 7.4 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр буурсан нь хувь хүнээс авах авлага барагдсантай холбоотойгоор буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 572.2 сая төгрөг болж 366.7 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 819.5 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр 6,322.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 6,775.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1,101.7 сая төгрөг, оны эцэст 1,132.6 мянган төгрөг болж 30.9 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 22.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант оны элэгдлийн зардал 63.8 сая төгрөг байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 916.7 сая төгрөг оны эцэст 1,249.5 сая төгрөг болж тайлант онд 332.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл -316.4 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,939.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,939.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1,939.2 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,939.2 сая төгрөгийн төсөв баталснаас 1,939.2 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,939.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,939.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,917.7 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь Цалингийн зардлыг 0.4 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.1 сая төгрөгөөр, нормативт зардлыг 0.8 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 14.1 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.3 сая төгрөгөөр урсгал зардлыг 5.7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 765.2 сая төгрөгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 5.3 сая төгрөгийг, Эрүүл мэндийн яамнаас 1,336.4 сая төгрөгийг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 211.1 сая төгрөгийг, цахим тендерийн хураамжийн орлогоор 1.1 сая төгрөгийн, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос 47.9 сая, Хувь иргэнээс 13.7 сая, сургалтын зардалд 0.7 сая төгрөгийг нийт 2,382.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж 2,377.2 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 5.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах асуудал байна. Үүнд:

Тайлант онд Ковид-19 цар тахал аймагт бүртгэгдсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 765.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож эм, 40239 ширхэг түргэвчилсэн оношлуур авахад 608.6 сая төгрөгийг зарцуулжээ. Үнэ төлбөргүй 170.0 сая төгрөгийн 13660 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 3,175.2 сая төгрөгийн 141275 ширхэг Ковид-19 цар тахлын эсрэг вакцин хүлээн авч данс бүртгэлдээ тусгажээ.

2021 онд түргэвчилсэн оношлуураар 53579 иргэнээс шинжилгээг авч, 1-р тунд 56454 иргэн 2-р тунд 53268 иргэнд 3-р тунд 24992 иргэн Ковид-19 цар тахлын эсрэг вакцинд хамрагджээ.

2021 онд 2 иргэнээс 4.2 сая төгрөгийн эм боох материал Өвөр монголын Алтай Цонж аймгаас 14.1 сая төгрөгийн эм боох материал, Онон сангаас 25.8 сая төгрөгийн эм боох материалын хандивыг авч данс бүртгэлд тусгажээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс 152 мэдээллийг хугацаандаа оруулсан, 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 24.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувь хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахалтай холбоотой худалдан авсан болон үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн зарцуулалт, шатахууны зарцуулалтыг хянаж үзэх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31.1 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 31.1 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж бичигдлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт бичигдээгүй.

4.3 Зөвлөмж

1. Эм боох материалын зарцуулалтай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан эм, боох материалын тайланг түүвэрлэн хянахад шаардах хуудас дутуу, гарын үсэг зурагдаагүй 23.6 сая төгрөгийн баримтаар зарлага гаргасан байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах" хуулийн заалтад нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

2. Авлагын бүртгэл

Илрүүлэлт: Тайлант онд 7.4 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийг баримтлан ажиллаж авлагыг хуулийн байгууллагад шилжүүлэн бүрэн шийдвэрлэн ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд аймгийн Эрүүл мэндийн газар	2	31.1	0	0	0	0	0	0	2	31.1

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР